

БАТЛАВ: БОР-ӨНДӨР СҮМҮН
ЗАСАГ ДАРГА ГАНХУЯГ

БАТЛАВ: Сүхбаатарын ЗАХИРАЛ
Сүхбаатарын ЗАХИРАЛ
СИ МОНГОЛЫН ХХК-НЫ ИГЭРЭЭНИЙ УЛАНБАТАРЫН ТӨССӨН

ЗДТГ УУЛ УУРХАЙН ХХК-ТАЙ БАЙГУУЛАХ ХАМТЫН АЖИЛЛАГАА,
ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2014 оны 10 сарын 27 өдөр

Бор-Өндөр сум

Нэг: Нийтлэг үндэслэл:

1.1. Гэрээний зорилго нь Бор-Өндөр сумын нутаг дэвсгэрт орших, тус сумын хөгжилд тодорхой дэвшил үзүүлэхуйц ашигт малтмалын газрыг ашиглахад гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар орон нутгийн нийгэм, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэн гадаад харилцааг хөгжүүлэх, шинээр ажлын байр бий болгож ядуурлын түвшинг бууруулахад оршино.

1.2. Энэхүү гэрээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай, Газрын тухай, Газрын хэвлэлийн тухай, Байгаль орчны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд явагдана.

1.3. Нэг талаас Бор-Өндөр сумын Байгаль хамгаалагч Энхбаатар овогтой Отгонтунгалаг нөгөө талаас *Сүхбаатарын ХХК-ийг* төлөөлж *2014 овогтой* *Фримен* нар 2014 оны 10-р сарын 27-ны өдрөөс эхлэн 1 жилийн хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

Хоёр: Бор-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын эрх, үүрэг:

- 2.1. Орон нутагтай тусгай зөвшөөрлий дагуу үйл ажиллагаагаа явуулахад сумын зүгээс шаардагдах үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх.
- 2.2. Олборлолт, үйлдвэрлэлт явуулах хугацаанд тэдний тавьсан хүсэлтийн дагуу төрийн үйлчилгээ хуулийн дагуу үзүүлна.
- 2.3. Үйлдвэрийн орчны аюулгүй байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэхийг шаардах
- 2.4. Хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийх.
- 2.5. Уурхайд шаардлагатай үед хүн эмнэлэг, соёлын болон цагдаагийн үйлчилгээг үзүүлэх.

2024.07

Гурав: Компаний хүлээх үүрэг:

- 3.1. *Сүрьеийн ААИ*, нь газрыг ашиглахдаа Монгол Улсын хууль тогтоомжууд болон аймаг, сум, орон нутгийн тогтоол шийдвэрүүдийн дагуу үйл ажиллагаагаа явуулна.
- 3.2. Ашигт малтмалын болон Усны тухай хуулийн дагуу төлбөр хураамжуудыг цаг хугацаанд нь төлнө.
- 3.3. Орон нутгийн татварын албанад бүртгүүлж суманд бүргтгэлтэй ААН болж 180-аас дээш хоног оршин суугаа иргэдийг орон нутагт бүртүүлнэ.
- 3.4. Орд, уурхай болон үйлдвэрийн газар ажиллах хүч, орон нутгаас авч ажиллах хүчийг сумын Засаг даргын тамгын газартай хамтран аймаг болон сум орон нутгаас сонгон авч өөрсдийн хөрөнгө хүчээр сургаж ажиллуулна.
- 3.5. Ажиллагсдад Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу цалин хөлс олгон хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн баталгаа, аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
- 3.6. Сумын Засаг Даргын үйл ажиллагааны хөтөлбөрыг дэмжин ЗДТГ-ын засвар, тохижилтод хувь нэмэр оруулах.
- 3.7. Эрүүл мэнд боловсрол соёл шинжлэх ухааны байгууллагыг дэмжин хамтран ажиллах, үйл ажиллагааг нь ивээн тэтгэх.
- 3.8. Байгаль орчныг хамгаалах, цөлжилттэй тэмцэх зорилгоор сумын төв болон уурхай эдэлбэр газрын орчимд цэцэрлэгжүүлэх, мод зүлэг тарих, ногоон байгууламж бий болгоно.
- 3.9. Сумын орчны бохирдол, хог хаягдал болон бусад асуудалд техник тоног төхөөрөмжийн дэмжлэг туслалцаа үзүүлэх.
- 3.10. Орон нутгийн хөгжилд мөнгөн хөрөнгө хуримтлуулж, сумын хөгжилд тодорхой дэмжлэг үзүүлнэ.
- 3.11. Орон нутагт зохиогдох соёл спортын үйл ажиллагааг дэмжин ажиллах.
- 3.12. Орон нутгийн иргэдийг газар тариалан эрхлэх, фермерийн аж ахуй байгуулах, малжуулах, хадлан хадах, малын тэжээлийн ургамал тариалах чиглэлд хөрөнгө мөнгөний дэмжлэг туслалцаа үзүүлэх.
- 3.13. Усны нөөц бүхий газар худаг гаргахад дэмжлэг үзүүлнэ.
- 3.14. Багийн Засаг дарга болон иргэдтэйгээ хамтран ажиллаж сумын хөгжилд хувь нэмэр оруулах.

Дөрөв: Хамтран хүлээх үүрэг:

- 4.1. Энэхүү гэрээг биелүүлэхэд хоёр тал санаачлага гаргаж ажиллана.
- 4.2. Талууд бичгийн зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
- 4.3. Хэрэв гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулах шаардлага гарах, эсхүл цуцлах тохиолдолд талууд бие биедээ 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

Тав: Гэрээг дүгнэх.

- 5.1. Энэхүү гэрээний биелэлтийг жил бүрийн эцэст 2 тал хамтран тооцож дүгнэнэ.
5.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй төхиолдолд дараагийн жилийн үйл ажиллагаа эхлүүлэхгүй бөгөөд гэрээг цуцлах үндэслэл болно.



Зөвшөөрсөн: ЗДТГазрын Дарга...../Б.АЛТАНСҮХ/
Багийн Засаг Дарга...../М.НАСАНМОНХ/

БОР-ӨНДӨР СУМЫН
БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ

...../Э.ОТГОНТУНГАЛАГ/


Утас: 99505195

С.Н.К.М.Х ХХК-ыг төлөөлж
 Ш.Аржаанх


Утас: 99791980